

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.14 № 117

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ундарга-Алтай ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Ундарга-Алтай ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд байгууллагын гадна өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор конторын барилгын гадна пасад, дээврийн засварыг 19,800.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Мөн ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад 20.263.2 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор тус байгууллагын бүтэц орон тоог 2 орон тоогоор бууруулж баталсан байна. Дээрх шийдвэрийн хүрээнд ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд 12,130.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 5 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 40 арга хэмжээ бүрэн, 4 арга хэмжээг 65.0 хувь буюу нийт дүнгээр 92.04 хувиар биелүүлж, биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн боловч ажлыг үнэлээгүй байна.

0702900384

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/сая. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	689.85	875.99
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,875.66	5,620.45
Нийт хөрөнгийн дүн	6,565.51	6,496.44
Нийт өр төлбөрийн дүн	4,713.70	4,422.00
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,851.81	2,074.44
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,565.51	6,496.44
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,446.99	2,532.69
Үйл ажиллагааны зардлын дүн	2,148.30	2,400.96
Үйл ажиллагааны үр дүн	298.69	2,530.29
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	298.69	2,530.29
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,376.67	3,387.57
Өмчид гарсан өөрчлөлт	-1,524.86	85.64
Тайлант оны үр дүн	-1,584.62	-1,398.77
Эцсийн үлдэгдэл	1,851.81	2,074.44
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,885.24	2,266.45
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,819.93	2,296.06
Үйл ажиллагааны ЦМГ	65.31	-29.61
Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.00	0.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	65.31	-29.61
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20.83	54.52
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54.52	3.32
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
Урсгал зардал		
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		

Гурав. Аудитын илрүүлэлт:

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар 32,146.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Тайланд шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн олговрыг авлагаар тусгаагүй, 1,078.2 мянган төгрөгийн өглөгийг тусгаагүй, биет бус хөрөнгийг 10,898.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, хөрөнгийн элэгдлийг 3,725.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, тайлант үеийн үр дүнг 5,152.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, орлого үр дүнгийн тайланд бусад зардлыг 5,456.0 мянган төгрөгөөр илүү, орлогын албан татварын зардлыг 572.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасныг зөрчсөн байна.

Хууль тогтоомжтой холбоотой: Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 3,903.3 мянган төгрөгийг дутуу шивсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 4,607.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,607.0 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрч 2,101.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 2,505.7 мянган төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн горим зөрчин дотор 378.9 мянган төгрөгийн, албаны бус хэрэгцээнд 645.6 мянган төгрөгийн шатахууныг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан бус хэрэгцээнд зарцуулсан шатахууныг төлүүлж төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Жолоочийн замын хуудасгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, зарцуулалт тодорхой бус 1,076.8 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан шатахууныг төлүүлж төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр болох 2,505.7 мянган төгрөгийг төсвөөс төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн нөхөн олговрыг буруутай этгээдээс нэхэмжлэн төсвийг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Данс бүртгэлд тусгагдсан нэгээс дээш жилийн насжилттай 263,032.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө,

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТБОНӨХЭ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“Ундарга-Алтай” ААТҮГ	7	32.1	1	3.9	6	28.2	7	32.1	-	-	-	-
Дүн	7	32.1	1	3.9	6	28.2	7	32.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
"Ундарга-Алтай" ААТҮГ	5	4.6	2	2.1	2	2.5	1	-	-	-	-	-
Дүн	5	4.6	2	2.1	2	2.5	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
“Ундарга-Алтай” ААТҮГ	3	27.4	-	-	3	27.4	-	-
Нийт дүн	3	27.4	-	-	3	27.4	-	-

хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулан ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Аймгийн ИТХ-аас төрийн албан хаагчдад орон нутгийн цалингийн нэмэгдэл олгох шийдвэр гаргасны дагуу 242,483.1 мянган төгрөгийн цалингийн зарлага нэмэгдсэн байна. Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах, өөрчлөлт оруулсан тохиолдолд эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 12 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.